

Нэгж: Санхүү, эдийн засгийн хэлтэс

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зориулалт	Техникийн тодорхойлолт	Үлд эгд эл /то о ши рхэ г/
1	Нягтлан бодох бүртгэлийн дансны нэгдсэн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	Багц	1	Албан шаардлагаар	Хавсралтаар	

Хавсралт: 3 хуудас



Нягтлан бодох бүртгэлийн дансны нэгдсэн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар

Нэр: Нягтлан бодох бүртгэлийн дансны нэгдсэн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах

Ажлын зорилго: “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хирээр мэдээллийн урсгалыг цэгцтэй, тодорхой болгох, нэгжүүдээс гарах мэдээ тайланг автоматжуулан, боловсронгуй хурдан шуурхай болгох, компанийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах боломж бүхий 15 системээс бүрдсэн ERP системд шаардлагатай дансны нэгдсэн төлөвлөгөө боловсруулах

Гүйцэтгэх хугацаа: Нийт ажлыг хийж гүйцэтгэж, дансны төлөвлөгөө, дансны зааврын эцсийн хувилбарыг хүлээлгэн өгөх хугацаа 2 сар байна.

Байршил: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв. “Эрдэнэс Тавантолгой” ХК

1. ҮНДЭСЛЭЛ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хирээр мэдээллийн урсгалыг цэгцтэй, тодорхой болгох, нэгжүүдээс гарах мэдээ тайланг автоматжуулан, боловсронгуй хурдан шуурхай болгох, компанийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах боломж бүхий 15 системээс бүрдсэн ERP системийг нэвтрүүлж байгаатай холбогдуулан нягтлан бодох бүртгэлийн дансны төлөвлөгөө, дансны зааврыг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

2. ХИЙГДЭХ АЖЛУУД

- Өмнө боловсруулагдсан өртөг, зардлын төвийн ангилал түүнд хуваарилагдах зардлын зүйлсийн ангилал, жагсаалтад үндэслэн нягтлан бодох бүртгэлийн орлого, зардал, хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч зэрэг санхүүгийн тайлангийн бүх дансдын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах,
- Дансны нэгдсэн төлөвлөгөө нь Монгол улсын хууль, дүрэм, журамд бүрэн нийцсэн байх бөгөөд төсөв, төсвийн гүйцэтгэлийг гаргах бүрэн боломжтой байх,
- Дансны нэгдсэн төлөвлөгөөг ERP програм хангамжтай уялдуулж, тестлэх,
- Дансны төлөвлөгөөний дагуу ажил гүйлгээг бүртгэх дансны заавар боловсруулах,

3. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

- Монгол улсын бүх хууль, дүрэм, журам
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
- Компанийн дотоод дүрэм, журмууд



4. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Олон улсын стандарт, Монгол улсын хууль, дүрэм, журам, компанийн дүрэм, журмуудад бүрэн нийцсэн дансны нэгдсэн төлөвлөгөө, дансны зааврыг Монгол хэл дээр бэлтгэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүлээлгэж өгнө.

5. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭТГЭЭД

- Хуулийн этгээд байна.

6. ТАВИГДАХ ХАМГИЙН БАГА ШААРДЛАГА

- Зөвлөхийн туршлага болон бусад мэдээллийг багтаасан дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх,
- Зөвлөхийн баг нь 3-аас доошгүй гишүүнтэй байх, гишүүн тус бүр нь магистраас доошгүй боловсролын зэрэгтэй байх,
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь нягтлан бодох бүртгэл, санхүү, аудитын чиглэлээр 10-аас доошгүй жил үйл ажиллагаагаа явуулсан байх,
- Зөвлөхийн багийн удирдагч нь Мэргэшсэн нягтлан бодогчийн эрхтэй, Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхтэй байх,
- Зөвлөхийн багийн удирдагч нь нягтлан бодох бүртгэл, санхүү, аудитын чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан байх,
- Зөвлөх нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг хэрэгжүүлж байсан туршлагатай байх,
- Уул уурхайн салбарт дансны нэгдсэн төлөвлөгөө, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, удирдлагын бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж байсан туршлагатай байх,
- Уул уурхайн салбарт санхүү, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх.

Анхааруулга: Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр ажлын даалгаврын хүрээнд хийгдэх ажилд зарим өөрчлөлтийг хийн гэрээнд тусгаж болно.